

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 07 дугаар сарын 17-ний өдөр

Улаанбаатар хот

| | Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа | Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан | Цаашид авч хэрэгжүүлэх арга зам | Оноо |
|--|---|--|---------------------------------|------|
| Үүрэг даалгавар НЭГ: Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу дүүргийн нутаг дэвсгэрт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх улсын байцаагчдын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажиллах. /Дүүргийн Засаг дарга нар/ | | | | |
| 1 | Нийслэлийн Засаг даргын А/728 дугаартай "Ажлын хэсэг байгуулах тухай" захирамжийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хүргүүлэн ажиллалаа. Ажлын хэсэг хуралдаж, холбогдох байгууллагад албан бичиг хүргүүлэн, хэрэгжилтийг хангах төлөвлөгөө гарган ажиллаж байна. | | | 30 |
| Үүрэг даалгавар ХОЁР: “Манай хороо - Миний гудамж” аяны хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбоодыг идэвхтэй оролцуулж, олон нийтэд сурталчлан таниулах ажлуудыг зохион байгуулах. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар/ | | | | |
| 2 | “Манай хороо - Миний гудамж” аяны хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дэх 104 СӨХ, 200 гаруй ААНБ-дыг идэвхжүүлэн ажиллаж байна. | | | 30 |
| Үүрэг даалгавар ГУРАВ: “Нийслэлийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, инженер хангамжийн засвар, шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах. /Захирагчийн ажлын алба, Инженер хангамжийн байгууллагууд, Хэрэгжүүлэгч агентлаг, Дүүргийн Засаг дарга нар/ | | | | |
| 3 | Өвөлжилтийн бэлтгэх хангах ажлын хүрээнд 12 салбарын 125 заалт бүхий төлөвлөгөө боловсруулж, зуны засварын ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Мөн авто замын зорчих хэсэг дэх нөхөн сэргээлт хийгдээгүй болон дутуу хийгдсэн байршлуудыг фото зургаар баримтжуулан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, нийслэлийн Замын хөгжлийн газарт албан бичгээр хүргүүлэхээр ажиллаж байна. | | | 30 |
| Үүрэг даалгавар ДӨРӨВ: Гамшиг ослын болон гол, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, авто замын барилга, байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах, үерийн далан сувгийн засвар шинэчлэл, цэвэрлэгээний ажлуудаа эрчимжүүлж ажиллах. /Нийслэлийн Онцгой байдлын газар, Дүүргийн Засаг дарга нар, Геодези, усны барилга байгууламжийн газар/ | | | | |
| | Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК-ний харьяа иргэдийн бүлгийн нийт 20 гаруй ажилтан албан хаагч үер усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор үерийн далан сувгийн цэвэрлэгээний ажлыг тогтмол хийж гүйцэтгэн ажиллаж байна. Нийт 26532м2 талбайн лаг, хог хаягдлыг цэвэрлэн ажилласан. Улаанбаатар хотын хэмжээнд 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс 07 дугаар 06-ны өдрийн хооронд үргэлжилсэн бороо орж 00.00-48.00 мм хур тундас унасан. Тэрэлж орчмоор 48.00 | | | 100 |

| | | | |
|---|---|--|-----|
| | <p>мм бороо орсон бол Улаанбаатар хот орчимд 5-7 мм бороо орж үргэлжлэн орсон борооны улмаас дүүргийн 19, 24 дүгээр хорооны Доод салхитын Сэлбэ голын усны түвшин нэмэгдэж 07 дугаар сарын 04-ний өдрөөс 07-ны өдрийг хүртэлх хугацаанд үерийн аюултай түвшингөөс 15 см давж Сэлбэ голын дагуух 200 орчим өрхийн 500 иргэн эрсдэлтэй нөхцөл байдалд орсон. Мөн 14, 19, 24 хорооны айлын хашаанд ус орж ирсэн, үерийн усанд өртсөн 25 дуудлага бүртгэгдсэн. Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх хүрээнд Сэлбэ гол дагуух 11 байршилд хамгаалалтын даланг босгож ажилласан. Мөн үер усанд боогдсон иргэдийг татан гаргах, хоол хүнсээр хангах ажлыг дүүргийн Гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн 262 алба хаагч, 9 механизм, 20 ачааны автомашинтайгаар 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс 07-ны өдрүүдэд зохион байгуулж 19,24 дүгээр хорооны 273 өрхийн 650 гаруй иргэний аюулгүй байдлыг ханган 1,5 км-ийн урттай даланг 156 машин шороо асгаж хүчитгэх ажлыг шуурхай зохион байгуулсан. Тус ажлыг зохион байгуулахад дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 41 алба хаагч 5 тээврийн хэрэгсэл, цагдаагийн газрын 35 алба хаагч 3 тээврийн хэрэгсэл, ЗДТГ-ын цэргийн штабын 5 алба хаагч, дүйцүүлэх 13 алба хаагч 1 тээврийн хэрэгсэл, Тохижилт үйлчилгээний ХХК-ийн 45 алба хаагч 1 ковш, 1 экскаватор, 15 ачааны машин, “Наши трейд” ХХК-ийн 19 алба хаагч 1 экскаватор, 5 ачааны автомашин ЗДТГ болон хороодын ажлын албанаас 104 алба хаагч 3 тээврийн хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэж ажилласан. Үерийн дараа урьдчилан сэргийлэх иргэдэд мэдээлэл өгөх ажлыг Дүүргийн Онцгой комисс болон Онцгой байдлын хэлтсээс гаргасан үер уснаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг Онцгой байдлын хэлтсийн 16 алба хаагч, Цагдаагийн хэлтсийн 15 алба хаагч 2 автомашинтай үерийн эрсдэлтэй бүсэд байршилтай 120 өрхийн 162 иргэнд хүргэж ажилласан.</p> | | |
| <p>Үүрэг даалгавар ТАВ: Гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, бохирын цооногт ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулах. /Дүүргийн Засаг дарга нар/</p> | | | |
| 5 | <p>Гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлонг ариутгах ажлыг 03 дугаар улиралд багтаан хийж гүйцэтгэнэ.</p> | | 30 |
| <p>Үүрэг даалгавар ЗУРГАА: Дүүргүүдийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилтын ажлуудыг дүүргүүдийн өмчид бүртгэж, эзэмшигч, ашиглагчийг тодорхой болгож, засвар, үйлчилгээ арчлалтыг хариуцан ажилладаг бодлого, чиглэл баримталж ажиллах. /Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Дүүргийн Засаг дарга нар/</p> | | | |
| 6 | <p>Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар бий болсон 6,834,373,743 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газраас ирсэн шийдвэр болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ыг тус үндэслэн байгууллагын даргын тушаалаар бүртгэж, эзэнжүүлэн, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажилласан.</p> | | 70 |
| <p>Үүрэг даалгавар ДОЛОО: Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж, холбогдох байгууламжуудын засвар үйлчилгээ, стандартыг дагуу тохижилтын ажлыг чанартай гүйцэтгэж, дуусгах. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар Хот тохижилтын газар Замын хөгжлийн газар, Бусад чиг үүргийн байгууллагууд/</p> | | | |
| 7 | <p>Үндэсний их баяр наадмын үеэр төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаа, үйлчилгээ явуулах нийт 94 аж ахуйн нэгж, иргэдэд зөвшөөрлийг олгосон. Хоолны чиглэлээр 40, хүнсний худалдааны</p> | | 100 |

| | | | | |
|---|--|--|--|-----|
| | <p>чиглэлээр 22, хүнсний бус худалдааны чиглэлээр 32 хүсэлтийг сонгон шалгаруулж зөвшөөрөл олгосон.</p> <p>Худалдаа, үйлчилгээ эрхлэх асар майхангүй иргэд, аж ахуйн нэгжүүдийг нэгдсэн журмаар нэг загварын 5x5 хэмжээтэй, 3x3 хэмжээтэй цагаан асар түрээслэн, жигдрүүлсэн.</p> <p>Үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж байгууллагын асруудыг нэгдсэн загвар бүхий дүүргийн логотой хаягаар жигдрүүлэн, байршил заасан дугаарыг гадна талд ил харагдахаар байршуулан ажилласан.</p> | | | |
| <p>Үүрэг даалгавар НАЙМ: <i>Хог хаягдалгүй байлгахад анхаарч, цэвэрлэгээний ажлыг сайтар зохион байгуулах. /Дүүргийн Засаг дарга нар Хот тохижилтын газар/</i></p> | | | | |
| 8 | <p>Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ ХХК” Төв цэнгэлдэх хүрээлэнд хуваарийн дагуу нийт 20 ажилтан албан хаагч 2 техник хэрэгсэлтэйгээр хог хаягдлыг хариуцан ажилласан.</p> <p>Дүүргийн 1-16 дугаар хороодын хог хаягдлыг хуваарийн дагуу тогтмол ачиж тээвэрлэн нийт 35 гаруй ажилтан 8 машин техниктэйгээр баярын өдрүүдэд 138 рейсээр 1456 тонн хог хаягдлыг ачиж тээвэрлэн ажилласан. Мөн зуслангийн бүсийн ачаалал нэмэгдсэнтэйгээр Найши трейд ХХК 12 машин техниктэйгээр өдөрт 3-4 удаагийн давтамжтайгаар нийт 125 рейсээр 1385 тонн хог хаягдлыг ачиж тээвэрлэн ажиллалаа.</p> <p>Дүүргийн 1-24 хороод тус бүр өөрийн нутаг дэвсгэрт баяр наадмын өмнөх өдрүүдэд цэвэрлэгээний ажлыг зохион байгуулан ажилласан.</p> | | | 100 |
| <p>Үүрэг даалгавар ЕС: <i>Хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хүнсний чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах урьдчилан сэргийлж ажиллах. /Захирагчийн ажлын алба, Эрүүл мэндийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Дүүргийн Засаг дарга нар/</i></p> | | | | |
| 9 | <p>Худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран холбогдох хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг хангуулах чиглэл өгөх сургалтыг Ерөнхий боловсролын 5 сургуулийн хурлын танхимд зохион байгуулан ажилласан. Сургалтын үеэр Төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаа, үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага болон зөвлөмжийг цаасан хэлбэрээр тараасан.</p> <p>2023 оны 07 дугаар сарын 10, 11, 12-ны өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнгийн хариуцсан талбайд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтнүүд хяналт тавин ажиллаж, зөвшөөрөлгүйгээр гарсан худалдаа, үйлчилгээг цаг тухай бүр нь Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газартай хамтран газар дээр нь зогсоож холбогдох арга хэмжээг авч ажилласан.</p> | | | 100 |
| <p>Үүрэг даалгавар АРАВ: <i>Баяр наадмын үеэр Хүй долоон худаг болон бусад газруудад үйл ажиллагаа явуулдаг хүүхдийн хөдөлгөөнт тоглоомуудын хөдөлмөрийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах. /Хотын стандарт хяналтын газар, Хөдөлмөр, халамжийн газар Дүүргийн Засаг дарга нар/</i></p> | | | | |
| 10 | <p>Төв цэнгэлдэх хүрээлэнд 2 цэгт хөдөлгөөнт тоглоомын үйл ажиллагаа явуулсан. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтнүүд</p> | | | 100 |

| | | | | |
|---|---|--|--|-----|
| | тогтмол хяналт тавин ажиллаж байсан. Баярын өдрүүдэд тус хөдөлгөөнт тоглоомуудтай холбоотой хүүхэд бэртэж, гэмтсэн тохиолдол гараагүй болно. | | | |
| Үүрэг даалгавар АРВАН НЭГ: Баярын өдрүүдэд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд хариуцлагатай эргүүл жижүүр ажиллуулах. /Нийт байгууллагууд/ | | | | |
| 11 | <p>Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/166 тоот “Үндэсний их баяр наадмын өдрүүдэд хариуцлагатай жижүүр томилох тухай” тушаалаар хэлтэс, тасгийн дарга, 1-24 зүгээр хороодын Засаг дарга нарыг үүрэгжүүлэн томилгоожуулж ажиллалаа.</p> <p>Хариуцлагатай жижүүрүүд 2023 оны 07 дугаар сарын 10-наас 07 дугаар сарын 14-ний өдрийн хооронд үүрэг гүйцэтгэхэд дүүргийн нутаг дэвсгэрт гарсан онцгой байдлын болон бусад зөрчилгүй тайван байлаа.</p> | | | 100 |
| Үүрэг даалгавар АРВАН ХОЁР: Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам сахиулах /Гадны орны жуулчдын аюулгүй байдлыг сайтар хангах/ /Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар Дүүргийн Засаг дарга нар/ | | | | |
| 12 | <p>Тулгар төрийн 2232, Их Монгол улсын 817, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмын амралтын өдрүүдэд тус цагдаагийн газраас нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнийг 2023 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 09 цагаас 07 дугаар сарын 14-ний өдрийн 09 цаг хүртэлх хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэгт шилжүүлэх тухай тус газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/41 дугаартай тушаалын хавсралтаар 24 цагаар ажиллах хариуцлагатай эргүүл, жижүүр, нэмэгдэл бүрэлдэхүүнийг томилон үүрэгжүүлэн, өдөр тутмын үйл ажиллагаанд нь хэлтэс, тасгийн дарга нараас биечлэн хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Дүүргийн 10-19, 21-24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт иргэд голын эрэг орчимд амарч зугаалж байхдаа согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхисноос үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5 чиглэлд 10 алба хаагчид явган эргүүлд, авто эргүүлийн 9 чиглэлд 18 алба хаагчид хүмүүст зөвлөмж, анхааруулга өгч ажиллаж байна.</p> <p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, гэмт хэргийн гаралтын түвшинг бууруулах зорилгоор оюутан, залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, гадаадын иргэд, жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр “Оюутан цагдаа-2023” арга хэмжээг хариуцсан дүүргийн 10 байршилд ажиллуулах саналыг хүргүүлж, хамтран ажиллаж байна.</p> | | | 100 |

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА П.БАЯНБААТАР

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Э.ХУЛАН

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Т.ТҮВШИНЖАРГАЛ